



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2023.04.20 № 01/6702
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Д. АМАРБАЯСГАЛАН
ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Авлигатай тэмцэх газраас авлигын шалтгаан, нөхцөлийг арилгах, авлига, ашиг сонирхлын зөрчлийг давтан гаргуулахгүй байх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн байгууллага, албан тушаалтанд холбогдох зөвлөмжийг хүргүүлж, арга зүйн туслалцаа, зөвлөгөөг өгч ажилладаг.

Энэ хүрээнд Боловсролын зээлийн сангаас олгож буй дотоод, гадаадын их, дээд сургуульд суралцах тэтгэлэг, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцан дүн шинжилгээ хийж, авлигын эрсдэлийг тогтоох, авлигаас урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулах зорилгоор тус сангийн Ажлын албанд ажиллав.

Ажиллах явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, биелэлт, үр дүнг Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6-д заасны дагуу нотлох баримтын хамт 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор хариуг ирүүлнэ үү.

Хувийг Боловсрол, шинжлэх ухааны яамд.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

Авлигатай тэмцэх газрын 2023 оны
04 дүгээр сарын 20-ны өдрийн
01/... дугаар албан бичгийн
хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ӨРХЛЭХ ГАЗАРТ

ЗӨВЛӨМЖ

Зөвлөмж 1. Боловсролын зээлийн сангийн ажлын албанд ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагааг ил тод, нээлттэй, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж хэвших, хүний нөөцийн ил тод байдлыг сайжруулах

Боловсролын зээлийн санд 2022 онд 21, 2023 онд 2 албан хаагч шинээр болон сэлгэн томилогдон ажиллаж байна. Гэтэл эдгээр албан тушаалтныг хэрхэн сонгон шалгаруулж, томилсон нь тодорхойгүй, ил тод байдлыг хангаагүй байна.

Тухайлбал, Боловсролын зээлийн сангийн захирлын 2020 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн А/48 дугаар тушаалаар баталсан “Шинэ ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах, дадлагажуулах журам”-ыг баримтлан горилогчийг ажилд авах асуудлыг зохицуулсан боловч албан хаагчдыг сонгон шалгаруулахдаа журамд заасан сонгон шалгаруулалтыг хэрхэн зохион байгуулсан нь тодорхойгүй, ажил горилогчидтой уулзалт хийж сонгон шалгаруулдаг талаар тайлбар хэлж байгаа боловч энэ талаар нотлох баримт хангалтгүй, хурлын тэмдэглэл үйлдээгүй, ажлын зарыг иргэд олон нийтэд мэдээлсэн байдал хангалтгүй байна.

Иймд ажлын албанд ажилтан сонгон шалгаруулахдаа “Шинэ ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах, дадлагажуулах журам”-ыг баримталж, энэ талаар нотлох баримтыг шат шатанд нь бүрдүүлж, ярилцлага хийсэн болон сонгон шалгаруулалтын талаар хурлын тэмдэглэл холбогдох баримтыг бүрдүүлж, хүний нөөцийн ил тод байдлыг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасныг мөрдөн ажиллах;

Зөвлөмж 2. Ажлын байрны тодорхойлолтод заасан шалгуур шаардлагыг хангасан иргэнийг томилон ажиллуулах, холбогдох дүрэм журмыг нэг мөр мөрдөж хэвшүүлэх

Боловсролын зээлийн санд ажлын байрны тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй хүмүүсийг томилон ажиллуулжээ.

Тухайлбал, Боловсролын зээлийн сангийн Ажлын албаны дарга Д.Гаридыг Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн Б/58 тоот тушаалын хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт”-д заасан албан тушаалын нэр зөрүүтэй, албан тушаалд тавигдах тусгай шаардлагын мэргэжил /нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засаг/, мэргэшлийн шаардлагыг хангаагүй байхад томилсон байна.

Мөн олон нийт, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэнд тавигдах ажлын байрны тодорхойлолтод “мэргэжлээрээ таваас доошгүй жил ажилласан байх” гэсэн тусгай шаардлагатай байтал энэхүү шаардлагыг хангаагүй Г.Энхмандалыг тус санд 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс өнөөдрийг хүртэл ажиллуулж байна.

Эдийн засагч мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод “мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байх” гэсэн тусгай шаардлага тавьсан байхад уг

шаардлагыг хангаагүй Л.Номин-Эрдэнийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс тус албан тушаалд томилон туршилтын хугацаагаар ажиллуулж байна.

Д.Батзаяа нь Сургалтын төрийн санд 2003 онд ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байхдаа нягтлан бодох бүртгэл мэргэжил эзэмшээгүй байсан ба уг ажилтан тушаалд томилогдсоноос хойш нэг жилийн дараа буюу Санхүү эдийн засгийн дээд сургуулийг 2004 онд “нягтлан бодох бүртгэл” мэргэжлээр төгссөн байна.

Иймд уг зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, ажлын байрны тодорхойлолтод нийцсэн иргэнийг сонгон шалгаруулж томилон, сэлгэн ажиллуулж, ил тод байдал, дотоод хяналтыг сайжруулах;

Зөвлөмж 3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах, буруутай үйл ажиллагаанд тухай бүр хариуцлага тооцож олон нийтэд мэдээлж хэвших.

Нийтийн албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг зөрчсөн байна.

Тухайлбал, Ажлын албаны дарга Д.Гарьд нь 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар “Урамшуулал олгох тухай” (40 хувь) 398,328.40 (гурван зуун ерэн найман мянга гурван хорин найман төгрөг дөчин мөнгө) төгрөгийг, 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/48 дугаар тушаалаар “Албан хаагчдын цалин хөлс, нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” (30 хувь) 508,746.60 (таван зуун найман мянга долоон зуун дөчин зургаан төгрөг жаран мөнгө) төгрөгийг, 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/51 дугаар тушаалаар “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” (25 хувь) 248,955.50 (хоёр зуун дөчин найман мянга есөн зуун тавин таван төгрөг тавин мөнгө) төгрөгийг, 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А/52 дугаар тушаалаар “Урамшуулал олгох тухай” (40 хувь) 398,328.40 (гурван зуун ерэн найман мянга гурван хорин найман төгрөг дөчин мөнгө) төгрөг нийт 1,544,358.90 (нэг сая таван зуун дөчин дөрвөн мянга гурван зуун тавин найман төгрөг ерэн мөнгө) төгрөгийн нэмэгдлийг өөртөө олгох шийдвэрийг гаргажээ. Ингэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг гаргаагүй байна.

Мөн Д.Гарди нь 2012 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан журмын дагуу Оросын Холбооны Улсад 2014-2016 онд зээлээр суралцжээ. Боловсрол, шинжлэх ухааны сайд 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/83 тушаалаар 32.000 ам.долларын зээлийг чөлөөлж, тус тушаалыг үндэслэж, Д.Гарди “Барьцаа хөрөнгө чөлөөлүүлэх тухай” өөрийн гарын үсэг бүхий албан бичгийг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Баянзүрх дүүргийн бүртгэлийн хэлтэст хүргүүлж, барьцаа хөрөнгийг чөлөөлүүлж байв. Энэ үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 6.3, 6.5, 8.1, 8.2, 11.1-т заасан журмыг зөрчсөн байна.

Иймд буруутай албан тушаалтанд хариуцлага тооцох, хууль бус шийдвэр бүртгэлийг хүчингүй болгуулах, арга хэмжээг авах, Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг сайжруулах.

Түүнчлэн дээрх төрлийн зөрчлийг давтан гарахаас урьдчилан сэргийлж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Боловсролын зээлийн сангийн холбогдох албан тушаалтнуудыг авлигын эсрэг сургалтад хамруулан Авлигын эсрэг хуулийн 8 дугаар

зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргуулж, зохих хяналтыг тавьж хэвших, хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг мөрдөж ажиллах;

Зөвлөмж 4. Гадаадад суралцагчдын зээлийн төлбөрийг чөлөөлөх асуудлыг хуульд нийцүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авах

Гадаадад суралцагчдын зээлийг чөлөөлөх асуудлыг “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал, Засгийн газрын 178 дугаар тогтоол, 2009 онд Засгийн газрын 242 дугаар тогтоолыг үндэслэн гадаадад суралцагчдын зээлийг анх 2008 оноос чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж эхэлсэн байна. Үүний дараа 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль батлагдан тус хуулиар суралцагчийн сургалтын төлбөрийг эргэн төлүүлэх, сургалтын зээлийг чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг Улсын Их Хурал журам гаргахаар хуульчилсан байна.

Гэтэл 2013 оноос өнөөдрийг хүртэл Боловсролын асуудал эрхэлсэн сайд нар Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 19 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн зээлээс чөлөөлөх тушаал гарган, шийдвэрлэж ирсэн нь 2011 оны Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д “суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох, хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

Боловсролын зээлийн сангаас олгож байгаа зээлийг чөлөөлөх журмыг Улсын Их Хурлаар тогтоогоогүй байхад салбарын сайд өөрт олгогдоогүй эрх хэмжээг хэрэгжүүлсэн нь илт хууль бус шийдвэр байна. /Хавсралт-1/

Иймд зөрчлийг арилгах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоож учирсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тайлагнах;

Зөвлөмж 5. Гадаадад суралцагчдын төлбөрийн зээлийг хууль, журам зөрчиж чөлөөлөх асуудлыг таслан зогсоож, хохирлыг нөхөн төлүүлэх

Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Гэрээний үүргийг дуусгавар болгох тухай” 2022 оны А/83 тушаалаар 40 төгсөгчийн гэрээний биелэлтийг тооцон, зээлээс чөлөөлөгдсөний 15, А/200 дугаар тушаалаар 10 төгсөгч чөлөөлсний 4, 2023 оны А/31 дүгээр тушаалаар 71 төгсөгчөөс 28, нийт 55 төгсөгчийн гэрээг дуусгавар болгон чөлөөлсөн нь хууль зүйн үндэслэлгүй байна. /Хавсралт-1/

2011 онд баталсан Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, суралцагчтай байгуулсан гэрээнд зээл чөлөөлөх зохицуулалт тусгагдаагүй байхад 5 жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн гэх үндэслэлээр зээлээс чөлөөлсөн нь 1.3 тэрбум төгрөгийн хохирол учирсан байж болзошгүй байна.

Мөн гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын зээлийг эргэн төлүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ холбогдох журмыг баримтлан ажиллаагүй буюу 1998 оны Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 67/131 тоот хамтарсан тушаалаар баталсан “Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”, Засгийн

газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, түүнийг үндэслэн гадаадад суралцагчтай үндэслэн байгуулсан гэрээнд “суралцагч нь гадаад улсад их дээд сургуульд суралцан төгсөөд гэрээнд заасан байгууллагад таваас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан тохиолдолд зээлийн болон төлбөрөөс чөлөөлөх хүсэлт гаргаж болно” гэж заажээ. Гэтэл хөнгөлөлтэй зээлээр гадаадад их, дээд сургууль төгссөн сурагчид гэрээний үүргээ биелүүлж, захиалагч байгууллагад ажиллаагүй байхад 700 иргэний зээлийг чөлөөлж улсад 1,597,768 /нэг сая таван зуун ерэн долоон мянга долоон зуун жаран найман/ ам.долларын хохирол учруулсан байж болзошгүй байна. /Хавсралт-2/

Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 тоот хамтарсан тушаалаар баталсан “Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам”-ыг зөрчсөн байна.

Тухайлбал, Жаргалсайханы Төрболд БСШУЯ-ны захиалгаар 2010-2012 онд АНУ-д суралцан төгсөж ирээд гэрээний дагуу захиалагч байгууллагад ажиллаагүй төдийгүй гэрээнд заасан хугацаа буюу нийгмийн даатгалын шимтгэлийн төлөлтийн хугацаа хүрээгүй байхад Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/31 дугаар тушаалаар сургалтын төлбөрийн зээлээс чөлөөлсөн байна.

Иймд дээрх хууль бус үйлдлийг таслан зогсоож, хууль тогтоомжид тодорхой тусган хэрэгжүүлэхэд анхаарч, хөнгөлөлтэй зээлээр гадаад улсад суралцаж, гэрээний үүргээ биелүүлээгүй төгсөгчдөөс хохирол нөхөн төлүүлэх асуудлыг зохион байгуулж ажиллах.

Зөвлөмж 6. Боловсролын зээлийн сангаас гадаадын их, дээд сургуульд тэтгэлэг олгох журмыг хуульд нийцүүлэн боловсронгуй болгож, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх

Дэлхийн шилдэг их сургуульд магистр докторын хөтөлбөрөөр гадаадын их, дээд сургуульд бакалаврын тэтгэлгээр суралцаж төгссөн иргэдийн сургалтын төлбөрийн зээл чөлөөлөх талаар хууль, дүрэм зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Дээр дурдсан зарим зөрчил, дутагдал давтан гарсаар байтал шинээр боловсруулан гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”, “Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит сургалтын тэтгэлэг олгох журам”-д чөлөөлөх үндэслэл, шалгуурыг журамлаагүй, нарийвчлан тусгаж өгөөгүй, хийдэлтэй, тодорхой бус зохицуулалт хийснээс гадаадын их, дээд сургуульд тэтгэлгээр суралцаж төгссөн иргэд Нийгмийн даатгалын шимтгэлийг хамгийн бага хэмжээгээр сайн дурын эсхүл хуулийн этгээдийн нэр дээр цалингийн доод хэмжээгээр төлж, зээлийн төлбөрийн чөлөөлөлтөд хамрагдаж, төсвийн хөрөнгийг үргүйдүүлэх эрсдэл хэвээрээ байна.

Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/31 дүгээр тушаалаар С.Оюунгэрэл цалингийн доод хэмжээгээр бүх шимтгэлээ төлсөн, Б.Халиун, Б.Цэрэнханд сайн дурын даатгалын шимтгэл төлсөн хугацааг тооцуулж чөлөөлөлтөд багтсан гэх мэт тохиолдол нийтлэг байна.

Зөвлөмж 7. Гадаадын их, дээд сургуульд зээлээр суралцах оюутны сургалтын төлбөрийг хувийн дансаар шилжүүлэхгүй байх, улсын төсвөөс гарсан мөнгөн төлбөрийг барагдуулах, нөхөн төлүүлэх, журмын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авах

Боловсролын зээлийн сангаас гадаадын их, дээд сургуульд зээлээр суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрийг тухайн оюутнуудын хувийн дансанд шилжүүлсэн зөрчлийг арилгах талаар Авлигатай тэмцэх газраас 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 02/353 дугаар албан бичгээр мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл мэдэгдлийн мөрөөр тодорхой үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулаагүй байна.

Тухайлбал, Гадаад улсад зээлээр суралцсан болон суралцаж байгаа нэр бүхий 17 иргэний сургалтын төлбөр болох нийт 835,173 ам.долларыг тус иргэдийн хувийн дансанд шилжүүлсэн зөрчлийг арилгах чиглэлээр арга хэмжээ авч нэг ч хүний төлбөрийг барагдуулаагүй байна. /Хавсралт-4/

Иймд гадаадын их, дээд сургуульд суралцаж байгаа оюутны төлбөрийг тухайн сургуулийн дансанд шилжүүлэх, шилжүүлгийг буруу хийсэн албан тушаалтанд зохих хариуцлагыг хүлээлгэж, цаашид энэ төрлийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, ажиллах.

Зөвлөмж 8. Боловсролын зээлийн сангаас хийгдэж буй мөнгөн гүйлгээг нягтлан шилжүүлэх, илүү төлөгдсөн мөнгийг буцаан төвлөрүүлэх арга хэмжээ авах.

Боловсролын зээлийн сангаас иргэний сургалтын төлбөр, замын зардлыг шилжүүлэхдээ холбогдох их, дээд сургуульд илүү шилжүүлсэн бөгөөд төлбөрийг буцаан төлүүлэх ажлыг гүйцэт зохион байгуулаагүй байна.

Тухайлбал, Боловсролын зээлийн сангаас 2015-2016 оны хичээлийн жилд нэр бүхий 3 сургуулийн оюутнуудын замын зардал болох нийт 187,301,500 төгрөгийг илүү шилжүүлснээс 6,546,000 төгрөгийг буцаан төлүүлээгүй байна.

Мөн тухайн хичээлийн жилд дэлхийн шилдэг 100 их, дээд сургуулийн бакалаврын түвшинд суралцаж байгаа 5 оюутны сургалтын төлбөрийг тухайн сургуулиас Австрали доллароор нэхэмжилсэн байна. Гэтэл нэхэмжилсэн төлбөрийг шилжүүлэхдээ 59,500 ам.долларын зөрүү үүсгэн илүү шилжүүлж, үүнээс нэг оюутан 16,650 ам.долларыг буцаан төлсөн байна. Үлдсэн 4 оюутны 42,850 ам.долларыг өнөөдрийг хүртэл буцаан төлөөгүй байна. /хавсралт-5/

Иймд үндэслэлгүй шилжүүлсэн мөнгөн төлбөрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх ажлыг яаралтай зохион байгуулж, буруутай үйлдэл гаргасан ажилтнуудад зохих хариуцлагыг ногдуулах.

Зөвлөмж 9. Боловсролын зээлийн сангаас зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж горилогчийн мэдээллийг цахимаар бүртгэх, үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, зээл авсан иргэдийн мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай уялдуулж, хяналт, ил тод байдлыг сайжруулах

Боловсролын зээлийн сангаас зээл авсан иргэдийн материал бүрдэлт дутуу, хангалтгүй, өнөөдрийг хүртэл гэрээний үүргээ биелүүлээгүйн зэрэгцээ, зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.

Тухайлбал, Боловсролын зээлийн сангаас гадаадын их, дээд сургуульд 2017-2014 оны хооронд Засгийн газрын 1997 оны 179, 2000 оны 96, 2008 оны 177, 2012

оны 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн бакалавр, магистр, докторт 230 иргэн зээл аван суралцсан мэдээлэл бүртгэлд байна.

Эдгээр иргэдийн баримт бичигтэй танилцаж, дүн шинжилгээ хийхэд Боловсролын зээлийн сангаас зээл авч гадаадын их, дээд сургууль төгссөн 5 иргэний холбогдох баримт, материал, 212 иргэний тус санд бүртгүүлсэн төгсөгчийн анкет, 217 иргэний суралцагчийн сургуулийн дипломын хуулбар, 218 иргэний ажилд орсон тодорхойлолт, 96 иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримт байхгүй, нийгмийн даатгалын шимтгэлийг 60 сарын турш төлөх ёстой байтал гадаадын их, дээд сургууль төгссөн 10 иргэн 12-50 сар хүртэлх хугацаанд төлсөн буюу гэрээний шаардлагад нийцээгүй, Боловсролын зээлийн сангаас нийт 156 иргэн гадаадын их, дээд сургуулийн зээл авахдаа барьцаа хөрөнгө байршуулаагүй буюу хөрөнгийн тайланд үнэлгээ хийлгэж, үл хөдлөх хөрөнгө барьцаалаагүй, 1 иргэн тус сантай зээлийн гэрээ байгуулаагүй зэрэг зөрчилтэй байв.

Дээрх үйлдэл нь Засгийн 2008 оны 177 дугаар тогтоолоор баталсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам", 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам", 2011 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах журам", суралцагч, Боловсролын зээлийн сантай байгуулсан зээлийн гэрээний үүргийг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрчлийг таслан зогсоох, арилгах, улсад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, дахин давтан гаргуулахгүй байхад анхаарч Боловсролын зээлийн сангаас зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламж горилогчийн мэдээллийг цахимаар бүртгэх, үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, улсын төсөвт хохирлыг буцаан төлүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, цаашид гадаадын их, дээд сургуулийн зээл авсан иргэдийг Монгол банкны зээлийн мэдээллийн сантай уялдуулах ажлыг зохион байгуулах.

Зөвлөмж 10. Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль зөрчсөн үйлдлийг давтан гарахаас урьдчилан сэргийлж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулан, тогтмол хяналт тавьж хэвших

Боловсролын зээлийн санд ажиллаж байх хугацаандаа гадаадын их, дээд сургуульд суралцсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11, 11.1, 22, 22.3.1-т заасныг тус тус зөрчсөн байж болзошгүй байна.

Тухайлбал, Боловсролын зээлийн сангийн ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Батзаяа 2013-2015 оны хичээлийн жилд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2008 оны 70/369 дугаартай гэрээний тушаалаар Америкийн Нэгдсэн Улсын Миссури сургуульд "Бизнесийн удирдлага" мэргэжлээр 2 жилийн хугацаатай 32.000.00 ам.долларын төлбөрийг сангаас зээлж, цахимаар суралцсан гэх боловч энэ талаар нотлох баримт, шаардлагатай бусад мэдээлэл байхгүй байна.

Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.5-т сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын алба эрхлэн гүйцэтгэхээр журамлаж, энэ хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг 2.8-т тодорхойлж өгсөн байна.

Тус сан нь дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид зохих журмын дагуу санхүүгийн дэмжлэг, суралцагчийн тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох, зээлийг эргэн төлүүлэх ажлыг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байхад зээлийг эргэн төлүүлэх, барьцаа хөрөнгийн баталгаа бүрдүүлэх, гэрээг зөрчсөн тохиолдолд нэхэмжлэл гаргах, эргэн төлөхөөс зайлсхийсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад хандах, хамтран ажиллах (журмын 2.8.4, 2.8.7, 2.8.9, 2.8.10, 2.8.11, 2.8.12, 2.8.13, 2.8.14, 6.1, 6.3, 6.10) зэрэг чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

Түүнчлэн дээрх журмын 6.4-6.6 дахь заалтад *Гадаадын их, дээд сургууль төгсөгч нь сургууль төгсөж, диплом авсан өдрөөс эхлэн 8 хүртэлх, дотоодын их, дээд сургуульд суралцагч нь төгссөнөөс хойш 6 хүртэлх жилийн дотор зээлийг төлж дууссан байхаар эргэн төлөлтийн хуваарийг гаргаж, зээлийн гэрээнд тодорхой тусгах; Журмын 6.4-т заасан хугацааг зээлдэгчийн хүсэлт, нөхцөл байдлыг үндэслэн 2 жил хүртэлх хугацаагаар нэг удаа сунгах; Суралцагч гэрээнд заасан хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлтийг Төрийн сан дахь Боловсролын зээлийн сангийн дансанд төлнө. Зээлийн гэрээнд зээлдэгчийн эрх, үүрэг, хариуцлага, зээлийн хэмжээ, эргэн төлөх нөхцөлийг тодорхой тусгаахаар заасан боловч эдгээр зохицуулалтыг хэрэгжүүлэхгүй байна.*

Тус сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт үр нөлөөгүй байгааг аудитын тайланд дурдсан байх боловч хяналт, хариуцлагыг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй байгаа нь учир дутагдалтай байна.

Иймд хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр нөлөөтэй дотоод хяналтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч үр дүнг тооцох шаардлагатай.

Зөвлөмж 11. Боловсролын зээлийн сангаас олгож байгаа гадаадын их, дээд сургуульд суралцагчдад олгох сургалтын зээлийг гэрээний дагуу эргэн төлүүлэх, төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах, Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллагын зүгээс тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх

Боловсролын зээлийн сангаас суралцагчтай байгуулдаг гэрээ буюу “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх тухай гэрээ”-ний загварыг Боловсрол, шинжлэх ухааны яам, Сангийн яам хамтран батлахдаа зээлийг эргэн төлөх, барьцаа хөрөнгөөс төлбөр барагдуулах асуудлыг тодорхой тусгаагүй, Засгийн газрын 2021 оны 347 дугаар тогтоолоор баталсан Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 6.3-6.6 дугаар зүйлд заасан журмыг мөрдүүлээгүйн улмаас зээлийг төлөхөөс зайлсхийх, үл хөдлөх хөрөнгийн барьцаа аваагүй, барьцаа хөрөнгийг өөрчлөх, солих, чөлөөлөх шийдвэр гаргаж байгаа боловч төлбөрийг барагдуулах асуудлыг хойш тавьдаг, мөн гэрээг зохих ёсоор дүгнэдэггүй, гэрээний үүргээ зөрчсөн буюу хугацаа хэтэрсэн байхад барьцаа хөрөнгөнөөс төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулдаггүй зэргээр чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байгаа нь учир дутагдалтай байна.

Түүнчлэн, зээлээс чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг дээрх журмын 8.4 болон 6.9-т заасан *Сантай гэрээ байгуулж үл хөдлөх хөрөнгө барьцаалан гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагч нь төгссөнөөс хойш 5-аас доошгүй жилийн хугацаанд мэргэжлээрээ Монгол Улсад ажилласан бол тухайн иргэний нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтад үндэслэн **хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ*** гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг зөрчсөн. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8-д *“суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох, хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журмыг Улсын Их Хурал тогтооно”* гэж заасантай нийцэхгүй байх ба уг журмыг мөрдөөгүй нь илт хууль бус юм.

Үүнээс гадна, тухайн суралцагчтай **байгуулсан гэрээнд** зээлийг хөнгөлөх, чөлөөлөх үндэслэл, нөхцөлийг зааж өгөөгүй байхад чөлөөлдөг, эсвэл Монгол Улсад 5 жилийн хугацаанд ажилласан мэтээр нийгмийн даатгалын шимтгэлийг хувиараа, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр төлдөг, өөрийн эзэмшлийн компанид туршилтаар ажиллах, аавынхаа туслахаар ажилласан гэх мэтээр зээлийг төлөхөөс зайлсхийх, мөн гэрээнд заасан хугацааг зохих ёсоор болон огт хангаагүй иргэнийг чөлөөлөх зэргээр хууль бус шийдвэр удаа дараа гаргаж байгаа нь шударга биш бөгөөд эдгээр зөрчил, дутагдлыг нэн даруй таслан зогсоож, хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, төлбөрийг эргүүлэн төлүүлэх шаардлагатай байна. /Хавсралт-2/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-т *Харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг хариуцан удирдаж, энэ хуульд заасан журмын дагуу хяналт тавьж, тайлагнах; түүнчлэн Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.1-т Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22.5-д зааснаар боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцан удирдах зэрэг чиг үүргийг тодорхойлж өгсөн* байна.

Иймд, - Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллага, салбарын сайдын зүгээс тавих хяналтыг сайжруулах, буруутай албан тушаалтанд хариуцлага тухай бүр тооцож хэвших, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч, үр дүнг тайлагнах;

- Боловсролын зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын хэрэгжилтэд мониторинг хийлгэж, цаашид хөндлөнгийн үнэлгээ, нийцлийн аудитын хяналтыг тогтмол зохион байгуулж, дүрэм журам болон үйл ажиллагааг сайжруулах;

- Зээлийн гэрээний загварыг шинэчилж дээр дурдсан зөрчил дутагдлыг гарах эрсдэлийг арилгах, зээлийг хууль тогтоомж болон гэрээнд заасан нөхцөл журмын дагуу төлүүлэх, хууль бусаар зээлээс чөлөөлсөн, барьцааг сулласан шийдвэрийг хүчингүй болгож зээлийн төлбөрийг төлүүлэх, хохирлыг барагдуулах ажлыг зохион байгуулах, буруутай этгээдэд хариуцлага тооцох, дахин давтан гаргахаас урьдчилан сэргийлэх.

---oOo---

Д/д	Зээлийн чөлөөлөлт	Огноо	Чөлөөлөгдсөн иргэдийн тоо	Зээлийн хэмжээ /ам.доллар/	Сайдын нэрс
1	ЗГ-ын 2008 оны 178 дугаар тогтоол	2008.05.14	50	930,168.60	
2	ЗГ-ын 2009 оны 242 дугаар тогтоол	2009.08.06	61	1,635,469.00	
3	БШУ-ны сайдын 2013 оны А/185	2013.05.22	199	5,078,024.90	Л.Гантөмөр
4	БШУ-ны сайдын 2013 оны А/475	2013.12.27	1	8,000.00	Л.Гантөмөр
5	БШУ-ны сайдын 2014 оны А/107	2014.03.24	105	2,938,348.60	Л.Гантөмөр
6	БШУ-ны сайдын 2014 оны А/212	2014.05.15	7	140,978.00	Л.Гантөмөр
7	БШУ-ны сайдын 2014 оны А/459	2014.11.25	25	692,697.67	Л.Гантөмөр
8	БСШУ-ны сайдын 2015 оны А/264	2015.07.01	49	1,387,895.68	Л.Гантөмөр
9	БСШУ-ны сайдын 2016 оны А/260	2016.06.23	51	1,369,120.48	Л.Гантөмөр
10	БСШУС-ын сайдын 2017 оны А/88	2017.07.27	51	1,376,814.00	Г.Чулуунбаатар
11	БСШУС-ын сайдын 2018 оны А/555	2018.08.31	74	1,829,371.00	Ц.Цогзолмаа
12	БСШУС-ын сайдын 2019 оны А/658	2019.10.18	69	2,202,827.80	Ё.Баатарбилэг
13	БСШУС-ын сайдын 2020 оны А/97	2020.02.21	13	408,000.00	Ё.Баатарбилэг
14	БШУ-ны сайдын 2020 оны А/195	2020.12.21	26	539,856.00	Ц.Цэдэвсүрэн
15	БШУ-ны сайдын 2021 оны А/312	2021.09.03	39	1,263,126.10	Л.Энх-Амгалан
16	БШУ-ны сайдын 2022 оны А/83	2022.03.14	40	1,155,090.93	Л.Энх-Амгалан
17	БШУ-ны сайдын 2022 оны А/200	2022.06.06	10	376,741.48	Л.Энх-Амгалан
Нийт			870	\$ 23,332,530.24	

Нэг. БШУ-ны сайдын 2021.09.03-ны А/312 тоот тушаалаар чөлөөлөгдсөн 39 төгсөгч

№	Нэр	Журам	Журмын хэрэгжилт / төгсөж ирээд гэрээнд заасан газраа ажилласан эсэх	НДШ сар
1	Д.Баяржаргал	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	104
2	Д.Уранчимэг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	95
3	Д.Лхагвасүрэн	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	
4	Д.Рэнчинмядаг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	128
5	Ш.Алтанбадралт	Генетик 1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	62
6	Д.Төрмөнх	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	144
7	З.Тулга	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	164
8	Т.Анхбаяр	2008.177.5	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	62
9	Х.Ундраа	2008.177.5	Гэрээнд заасан газраа ажилласан	62
10	Б.Батцоож	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	72
11	Г.Зандан	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	67
12	Б.Оюунчимэг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	64
13	Д.Нямбат	2008.177.5	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	60
14	Ц.Ганболд	2008.177.5	Гэрээнд заасан газраа ажилласан	96
15	Б.Баттогтох	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	64
16	Д.Отгонцэцэг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	100
17	Д.Нарантуяа	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	138

18	А.Молор-Эрдэнэ	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	72
19	Ц.Гантөгс	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	90
20	Э.Болормаа	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	160
21	Б.Энхжаргал	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	75
22	С.Энхчимэг	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	72
23	Б.Батсүх	2008.177.5	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	66
24	Э.Тамир	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	84
25	Л.Бадамцэцэг	1998.67/131	СЯ, Гэрээнд заасан газраа ажиллаагүй	132
26	Т.Сосорбарам	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	84
27	Д.Золжаргал	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	96
28	Ч.Алтанхуяг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	188
29	Н.Туяа	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	124
30	М.Мөнхбаяр	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	88
31	Ц.Анхбаяр	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	96
32	Э.Халиун	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	64
33	Д.Мэндсайхан	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
34	Х.Саруул	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
35	М.Отгонпүрэв	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	66
36	П.Баасанхүү	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажилласан	162
37	Д.Мөнхтүшиг	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	164
38	А.Заяадэлгэр	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	63
39	У.Сийлэн /Б/	1998.67/131	Гэрээнд заасан газраа ажиллаагүй	63

Хоёр. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.03.14-ний өдрийн А/83 тушаалаар чөлөөлөгдсөн 40 төгсөгч

№	Нэр	Журам	Журмын хэрэгжилт	НДШ сараар
1	Б.Цэгмид	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	76
2	Н.Тамир	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	119
3	Б.Айбек	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	147
4	М.Туяа	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	60
5	Ж.Отгонбаатар	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	88
6	Т.Тэлмэн	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	128
7	Б.Мөнхсайхан	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	102
8	Ц. Уянга	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	Тахир дутуугийн тэтгэвэр
9	Э.Мөнхмарал	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	99
10	Т.Ганбат	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
11	Б.Дөлгөөн	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	66
12	Д.Түвшинжаргал	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
13	Д.Мөнхдэлгэр	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	64
14	Г.Цэрэннадмид	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
15	Б.Эрдэнэсүрэн	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	111
16	С.Амгаланбат	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	65
17	Б.Одгэрэл	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	66
18	Л.Отгонбаяр	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	71
19	Б.Золжаргал	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	82
20	Д.Ананд	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	76
21	Н.Мөнхжин	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	68
22	Г.Түвшинжаргал	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	71
23	Б.Мөнхжин	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
24	Д.Гарди	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
25	Г.Нямсүрэн	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
26	Ч.Тэмүүлэн	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
27	Ц.Хүрэлбаатар	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	100
28	А.Дашцэрэн	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	81
29	Д.Мөнхцэцэг	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	73
30	Б.Баяржаргал	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	67
31	Н.Батчимэг	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	60

32	О.Дуламсүрэн	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	61
33	Э.Булган	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
34	О.Цолмон	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	62
35	Э.Ариунзаяа	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	61
36	Б.Батзаяа	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	64
37	А.Билгүүнтөгс	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	65
38	Д.Дуламсүрэн	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	60
39	Б.Арна	1998 оны 67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	63
40	О.Энхцолмон			66

Гурав. 2022.06.06-ны өдрийн А/200 дугаар тушаалаар чөлөөлөгдсөн 10 төгсөгч

№	Нэр	Гэрээнд заасан газраа ажилласан эсэх	Журмын хэрэгжилт	НДШ сараар
1	Ч.Баярхүү	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	70
2	М.Мөнхөө	2008.177.5	ХЗДХЯ ажилласан	134
3	Б.Баяртунгалаг	2008.177.5	ШУТИС гэрээнд заасан газраа ажиллаагүй	68
4	Ж.Хулан	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	88
5	Г.Халиунаа	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
6	Г.Марал	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
7	Б.Баттөр	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	70
8	Б.Батдорж	2008.177.5	ХЗДХЯ, гэрээнд заасан газраа ажилласан	61
9	А.Мөнхжин	2013.271.	Зээл чөлөөлөх заалт байхгүй	24
10	М.Долгормаа	Инженер технологийн дээд боловсрол төсөл	МУИС, гэрээнд заасан газраа ажилласан	60

Дөрөв. 2023.02.01-ний өдрийн А/31 дүгээр тушаалаар чөлөөлөгдсөн 71

№	Нэр	Журам	Журмын хэрэгжилт	НДШ сараар
1	Ш.Мөнхбат	2008.177.5	Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо гэрээнд заасан газраа ажилласан	74
2	Ч.Эрдэнэбилэг	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	76
3	Ц.Ариунжаргал	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	96
4	Ж.Дамдинцэрэн	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	49
5	Б.Намуун	2008.177.5	ХХААХҮЯ ажиллаагүй	9
6	Ц.Саранцэцэг	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	62
7	Б.Батцэцэг	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	65
8	С.Оюунгэрэл	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	-
9	А.Хассод /Б/	2008.177.5	Хувийн хэвшил Мэйк ХК ажиллаагүй	66
10	Р.Оргилмаа	2008.177.5	УИХ-ын Тамгын газар, ажилласан	65
11	Б.Мөнхбаясгалан	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	41
12	Б.Мандхай /Б/	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	81
13	Г.Дариймаа	2008.177.5	БСШУЯ, гэрээнд заасан газраа ажиллаагүй	29
14	Ц.Түвшинбаяр	2008.177.5	ЦЧМТ ХХК гэрээнд заасан газраа ажилласан	86
15	Б.Алтанчимэг	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	48
16	Х.Амантай	2008.177.5	БСШУЯ гэрээнд заасан газраа ажилласан	34
17	Б.Тэнгис	1998.67/131	Түлш эрчим хүчний яам, оюу толгойд гэрээнд заасан газраа ажилласан	126
18	Б.Мөнх-Оргил	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	71
19	Б.Мишээл	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	41
20	Г.Өнөрбаяр	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	21
21	Т.Хишгээ /Б/	2008.177.5	ХЗДХЯ, ажиллаагүй	14

22	Б.Сарнай	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	35
23	Ө.Баттулга	2008.177.5	Монгол банк ажилласан	70
24	А.Жавхлантуяа	2008.177.5	ШУА, хангалттай	67
25	Д.Энхчимэг	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	45
26	Ж.Бямбажав /Б/	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	85
27	М.Баттулга	1998.67/131	ШУА, ажиллаагүй	61
28	Б.Отгонбаатар	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	81
29	А.Бат-Эрдэнэ	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	70
30	Б.Галбадрах	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	61
31	Ц.Саруул	2008.177.5	ЭМЯ, ажилласан	42
32	Б.Баттулга	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	47
33	С.Ганзориг	2008.77.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	61
34	Б.Энхболд	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	75
35	Б.Тэгшжаргал	1998.67/131	Барилга архитектур корпорац, гэрээнд заасан газраа ажиллаагүй	81
36	Ч.Мөнхчулуун	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	68
37	С.Оюундэлгэр	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	8
38	В.Энхбаатар	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	70
39	З.Мөнхсайхан	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	63
40	Ц.Пүрэвхүү	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	60
41	Ш.Одонням	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	79
42	Г.Бодьбилгүүн	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	68
43	Д.Амаржаргал	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	62
44	Н.Уянга	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	51
45	Ц.Билгүүн	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	67
46	Э.Сайнзаяа	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	60
47	С.Цэрэндаш	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	68
48	Г.Мөнхзул	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	70
49	Ш.Эрдэнэбаяр	2008.177.5	Монгол банк, гэрээнд заасан газраа ажиллаагүй	109
50	Х.Эрдэнэдалай	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	68
51	А.Оюунцацрал	2012.19.04	Зээл чөлөөлөх заалт байхгүй	43
52	М.Мөнгөнхуяг	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	61
53	Т.Энхжин	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	60
54	Б.Халиун	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	
55	Д.Цолмон	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	65
56	Б.Хулан	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	39
57	М.Гантулга	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	62
58	Б.Мөнх-Од	2008.177.5	Захиалагч байхгүй гэрээндээ	76
59	Д.Номин	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	88
60	Ш.Ариунбаяр	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	72
61	М.Оюунчимэг	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	71
62	Ч.Чинцолмон	1998.67/131	БСШУЯ, гэрээнд заасан газраа ажиллаагүй	82
63	Л.Мөнхжаргал	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	84
64	Ч.Сүхбаатар	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	74
65	Л.Мөнхнасан	2008.77.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	36
66	Ж.Төрболд	2008.177.5	БСШУЯ, гэрээнд заасан газраа ажиллаагүй	30
67	Б.Түвшинтунгалаг	2008.177.5	МУИС, гэрээнд заасан газраа ажиллаагүй	44
68	Б.Баттүвшин	2012.19.4	Зээл чөлөөлөх заалт байхгүй	77
69	Б.Цэрэнханд	2008.177.5	Зээл чөлөөлөх зохицуулалттай	8
70	Д.Ариунаа	2008.177.5	БСШУЯ, ажиллаагүй	21
71	Я.Халиун	1998.67/131	Зээл чөлөөлөх зохицуулалттай	84

---оОо---

№	Тушаалын дугаар	Зээлээр суралцсан иргэний нэр	Санхүүжилтийн хэмжээ /ам доллар/
1	БШУ-ны сайдын 2021.09.03-ны А/312 тоот тушаал	С.Энхчимэг	32,000
2		Ц.Анхбаяр	32,000
3		Э.Халиун	16,000
4		Д.Мэндсайхан	32,000
5		Х.Саруул	82,658,75
6		М.Отгонпүрэв	71,955,00
7	БШУ-ны сайдын 2022.03.14-ний өдрийн А/83 тушаал	Б.Дөлгөөн	32,000
8		Т.Ганбат	22,500
9		Д.Түвшинжаргал	27,846
10		Д.Мөнхдэлгэр	32,000
11		Г.Цэрэннадмид	32,000
12		Н.Мөнхжин	12,750
13		Г.Түвшинжаргал	10,000
14		Б.Мөнхжин	16,000
15		Д.Гарди	32,000
16		Г.Нямсүрэн	16,000
17		Ч.Тэмүүлэн	32,000
18		Э.Булган	32,000
19		О.Цолмон	58,640
20		А.Билгүүнтөгс	24,000
21	О.Энхцолмон	2,375,800/иен/	
22	БШУ-ны сайдын 2022.06.06-ны өдрийн А/200 дугаар тушаал	Ч.Баярхүү	31,980
23		Ж.Хулан	16,000
24		Г.Марал	32,000
25		Б.Баттөр	12,120
26	БШУ-ны сайдын 2023.02.01-ний өдрийн А/31 дүгээр тушаал	Г.Халиунаа	30,713.10
27		А.Мөнхжин	125,938.29
28		Ц.Ариунжаргал	32,000
29		Ц.Саранцэцэг	32,000
30		Б.Алтанчимэг	10,000
31		Б.Мөнх-Оргил	32,000
32		Б.Мишээл	10,000
33		Б.Сарнай	31,891
34		Д.Энхчимэг	32,000
35		Ж.Бямбажав	32,000
36		Б.Отгонбаатар	48,000
37		Б.Галбадрах	16,000
38		Б.Баттулга	32,000
39		Б.Энхболд	32,000
40	Ч.Мөнхчулуун	41,500	
41	БШУ-ны сайдын 2023.02.01-ний өдрийн А/31 дүгээр тушаал	С.Оюундэлгэр	16,000
42		В.Энхбаатар	32,000
43		З.Мөнхсайхан	11,890
44		Ц.Пүрэвхүү	32,000
45		Д.Амаржаргал	48,000
46		Н.Уянга	24,000
47		Б.Баттүвшин	32,000
48		С.Цэрэндаш	32,000
49		А.Оюунцацрал	32,000
50		Б.Халиун	32,000
51		Д.Цолмон	32,000
52		М.Гантулга	32,000
53		Д.Номин	32,000
54		Ш.Ариунбаяр	32,000
55		Ч.Сүхбаатар	32,000

№	Тушаалын дугаар	Гэрээт байгууллагад ажиллаагүй хүний тоо
1	БШУ-ны сайдын 2021.09.03-ны А/312 тоот тушаал	39/24
2	БШУ-ны сайдын 2022.03.14-ний А/83 тушаал	10/8
3	БШУ-ны сайдын 2022.06.06-ны А/200 дугаар тушаал	
4	БШУ-ны сайдын 2023.02.01-ний А/31 дүгээр тушаал	

---oOo---

Тайлбар: Боловсролын зээлийн сангаас олгож байгаа зээл, тэтгэлэгтэй холбоотой зарим баримт, материалыг үзэх боломжгүй буюу хязгаарлагдмал байсан болно.

СУРАЛЦАГЧИЙН ХУВИЙН ДАНС РУУ ШИЛЖҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

№	Суралцагчийн нэр	ЗГ тогтоол	Сайдын тушаалын дугаар	Суралцсан улс	Сургууль	Мэргэжил	Санхүүжилт	АТГ-ын албан тоотын хэрэгжилт, үр дүн	
1	Шагдаржав Эрдэнэсүвд	271	2014.05.20 №А/219, 2014.10.20 №А/413	Австрали	Сидней ИС-Квинслэндын ИС	Мэдээллийн технологи	137,310.00	Сургуулиа төгссөн	2020 онд төгссөн бүртгэл хийлгэсэн, магистрт суралцаж байгаа- монголд ирээгүй, итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй холбогдож гэрээний үүргээ биелүүлэхийг сануулан ажиллаж байна.
2	Наянтай Цолмон	271	2015.05.04 №А/155	АНУ	Вашингтон ИС	Хүрээлэн буй Орчин	188,778.50	Сургуулиа төгссөн	MOT Wealth ХХК-д ажиллаж байгаа холбоо тогтоон ажиллаж байна.
3	Баянбилэг Анударь	271	2015.11.11 №А/454 2019 11.15 №А/742	Канад	Бритиш Колумбия ИС	Уул уурхай	96,319.68	Төгсөөгүй	Итгэмжлэгдсэн төлөөлөгч болон анкетад байгаа утсаар холбогдсон ч утас солигдсон байсан. /2023.03/
4	Баттайван Анар	271	2015.11.11 №А/454	Швейцари	Цюрих ИС	Механик инженер	63,536.00	Төгсөөгүй	Хувийн дансаар сургалтын төлбөр авах ямар нэгэн хүсэлт байхгүй байна
5	Батцогт Анударь	271	2016.05.25 №А/215	Англи	Кингс Коллеж Лондон	Соёл	45,855.00	Сургуулиа төгссөн	Сургуулиа төгсөж ирээд "Жавхланта Орд" ХХК-д ажиллаж байгаа бөгөөд
6	Цолмонхүү Удвал	271	2016.05.25 №А/215	АНУ	Капифорния ИС Санта Барбара	Эмч	87,580.00	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
7	Содномцогт Сайханбаяр	271	2015.05.04 №А/155	Швейцари	Цюрих ИС	Механик инженер	50,292.00	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
8	Бямбажав Өгөөмөртэмүүлэн	271	2015.05.04 №А/155- 2015.08.24 №А/328	Австрали	Сидней ИС	Боловсрол	14,753.00	Сургуулиа төгссөн	Сургуулиа төгсөж ирээд "Хүү мөнх" ХХК-д ажиллаж байна.

9	Эрдэнэтуяа Эрдэнэбаяр	271	2015.11.11 №А/454	АНУ	Иллинойс ИС	Барилгын инженер	36,016.00	Сургуулиа төгссөн	Сургуулиа төгсөж ирээд "Сүүтэй" ХХК-д ажиллаж байгаа бөгөөд холбогдон ажилласан.
10	Дэлгэрбаяр Удвал	271	2016.05.25 №А/215	Англи	Манчестэр ИС	Боловсролы н эрхзүй	6,021.00	Сургуулиа төгссөн	Хүнс тэжээл Нийгмийн хангамж нэмэлт санхүүжилт төсөл хариуцан ажиллаж байна.
11	Ариунболд Чинсанаа	271	2017.07.06 №А/67- 2018.12.10№ А/779	АНУ	Баруч Коллеж-Норт Ийстерн ИС	Эдийн засагч	6,166.25	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
12	Чулуунзоригт Цогжавхлант	271	2018.05.04 №А/275	Канад	Торонто ИС	Актурч	34,339.00	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
13	Нэргүй Ариун- Эрдэнэ	271	2017.01.25 №А/21	АНУ	Калифорния ИС	Бизнесийн Удирдлага	2,106.00	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
14	Ариунболд Сайханчимэг	271	2016.05.25 №А/215	Канад	Бритиш Колумбия ИС	Архитектур	35,539.00	Төгсөөгүй	Сургууль руу нь холбогдон ажиллаж байна.
15	Лувсандэш Лувсанханд	271	2016.05.25 №А/215	АНУ	Висконсин ИС	Биологи	15,741.52	Төгсөөгүй	ШУА Биологийн академид ажиллаж байгаа
16	Чимэд-Юндэн Намуундарь	271	2014.08.11 №А/319	АНУ	Калифорния ИС	Математик статистик	2,254.00	Сургуулиа төгссөн	Монгол банканд эдийн засагчаар ажиллаж байгаа холбогдон ажилласан
17	Эрдэнэбилэг Ану	271	2013.06.06 №А/217	АНУ	Массачусетс ИС	Бизнесийн удирдлага	12,567.00	Сургуулиа төгссөн	"Говь" ХХК менежерээр ажиллаж байна холбогдон ажилласан
Нийт дүн							835,173.95		

---oOo---

**ДЭЛХИЙН ШИЛДЭГ 100 ИХ, ДЭЭД СУРГУУЛЬД БАКАЛАВРЫН ТҮВШИНД СУРАЛЦСАН 5 ОЮУТАНД АВСТРАЛИ, КАНАД ДОЛЛАРЫГ
АМ.ДОЛЛАРООР БОДОЖ ИЛҮҮ ШИЛЖҮҮЛСЭН ЗӨРЧИЛ**

№	Овог нэр	Засгийн газрын тогтоолын дугаар	Тушаалын дугаар	Улсын нэр	Сургуулийн нэр	Мэргэжил	2023.03.23-27-ны байдлаар	
							Илүү төлсөн сургалтын төлбөр буюу USA төлбөр	Тайлбар
1	Баянбилэг Аударь	271	2015.11.11 №А/454 2019 11.15 №А/742	Канад	Бритиш Колумбия ИС	Уул уурхай	22,852.93	2022 оны 3 дугаар сарын 27-ны өдөр иргэн Б.Аударьтай холбогдон уг сургалтын төлбөрийн буюу илүү төлөлтийг буцаан төлөхийг мэдэгдсэн. Сургуулиа төгсөж ирээд Их хурлын тамгын газарт ажиллаж байна.
2	Гансэлэм Баттүшиг	271	2014.08.11 №А/319	Канад	Бритиш Колумбия ИС	Цахилгааны инженер	13,160.58	Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй нь холбоо тогтоон ажиллаж байна. Сургуулиа 4 жилийн өмнө төгсөж ирээд ажиллаж байгаа болно. Илүү шилжүүлсэн 13160.58 ам долларыг буцааж төлөхийг мэдэгдсэн.
3	Зоригтбаатар Намуундарь	271	2015.11.11 №А/454	АНУ	Мэссачусетс ИС	Барилгын инженер		2015-2016 оны сургалтын төлбөрөөс илүү шилжүүлснийг 16650 ам дол-г дараагийн сургалтын төлбөрөөс суутгасан байна
4	Дэлгэржаргал Дэлгэрзаяа	271	2015.11.11 №А/454	АНУ	Вашингтон ИС	Байгаль орчин	223.00	Итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй нь холбоо тогтоон ажилласан. Сургуулиа 4 жилийн өмнө төгсөж ирээд ажиллаж байгаа болно. Илүү шилжүүлсэн 223 ам долларыг буцааж төлөхийг мэдэгдсэн.
5	Лхагвасүрэн Сарнай	271	2017.01.25 №А/21	Австрали	Нью Саут Вельсийн ИС	Нисэхийн менежмент	6,614.37	Холбоо барьж чадаагүй болно.
Нийт							42,850.88	

---oOo---